



I-XI/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 12




## Нийтийн хоолны салбарын орлого өмнөх сараас 1.5 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний 11 сард 570.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.0 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсөж, харин бодит дүнгээрээ 5.2 хувиар буурчээ. Үүнд захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 5.6 (5.1%) тэрбум төгрөг, рестораны орлого 1.2 (0.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны 10 дугаар сард 74.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.2 (6.1%) тэрбум төгрөг, 11 дүгээр сард 75.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.1 (1.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 11 сард



Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсөж, харин рестораны орлогын эзлэх хувь 0.5 нэгж хувь, баарных 0.2 нэгж хувь, гуанзных 0.1 нэгж хувиар тус тус буурсан байна.


## Зочид буудлын салбарын орлого өмнөх сараас 4.7 хувиар буурчээ

Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний 11 сард 188.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.2 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар өсөж, харин бодит өсөлт нь 6.8 хувь байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 14.5 (13.8%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрын орлого 8.8 (15.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны 10 дугаар сард 29.0 тэрбум төгрөг болж өмнөх сараас 5.9 (25.8%) сая төгрөгөөр өсөж, харин 11 дүгээр сард 27.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.4 (4.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 2.3 (11.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2021 оны эхний 11 сарын орлогын 63.6 хувийг 3 ба түүнээс дээш одтой зочид буудал, 34.5 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 1.8 хувийг 2 одтой зочид буудлын орлого эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 11 сард



**Ойлголт, тодорхойлолт:**

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



**Эх үүсвэр:**

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

**Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гархах хуваарь:**

2022 оны 2 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын статистикч Ч.Мөнхтуул  
Утас : (976-51)-264797

